

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/96/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: А.Оюундэлгэр

Утас: 99306289

цахим хаяг: a_oyund@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал.....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ДУУТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА

**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022 02.09 № 02/13
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дуут сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дуут сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансныкод	Балансынүзүүлэлт	Эхнийүлдэгдэл	Эцсийнүлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,986,881	22,505,145
33	АВЛАГА	1,979,974	2,098,138
33100	Ажиллагчидтайхолбогдсонавлага	-	79,764
335	Бусадавлага	1,979,974	2,018,374
3352	Хувьхүмүүсээсавахавлага	1,979,974	2,018,374
35	БАРАА МАТЕРИАЛ	21,006,907	20,407,007
351	Түүхийэдматериал	1,347,400	246,000
35130	Эмбоохматериал	1,347,400	246,000
354	Хангамжийнматериал	19,659,507	20,161,007
35420	Ажахуйнматериал	10,674,718	11,430,418
35460	Хүнснийматериал	8,984,789	8,730,589
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	378,323,903	360,062,551
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	378,323,903	360,062,551
392	Биетхөрөнгө	374,029,153	355,882,051
39201	Барилга, байгууламж, оронсууц	384,049,187	389,049,187
39202	Хуримтлагдсанэлэгдэл	(39,704,602)	(54,990,622.)
39205	Машинтоногтөхөөрөмж (компьютер)	40,213,672	40,213,672
39206	Хуримтлагдсанэлэгдэл	(27,925,815)	(31,810,408)
39207	Тавилга, ажахуйнэдхогшил	46,732,480	46,732,480
39208	Хуримтлагдсанэлэгдэл	(29,751,767)	(33,728,256)
39217	Ном	416,000	416,000
393	Биетбусхөрөнгө	4,294,749	4,180,499
39301	Програмхангамж	532,000	532,000
39302	Хуримтлагдсанэлэгдэл	(189,250)	(303,500)
39303	Бусадбиетбусхөрөнгө	3,952,000	3,952,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	401,310,784	382,567,696
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	401,310,784	382,567,696
51	Засгийнгазрынхувьоролцоо	401,310,784	382,567,696
511	Засгийнгазрыноруулсанкапитал /Засгийнгазрынсан/ ороннуггийнсан	792,728,729	792,728,729
51101	Өмч: - төрийн	792,728,729	792,728,729
512	Хуримтлагдсанүрдүн	(393,185,685)	(411,928,773)
51210	Өмнөхүеийнүрдүн	(393,185,685)	(393,185,685)
51220	Тайлантүеийнүрдүн	-	(18,743,087)
51300	Хөрөнгийндахинүнэлгээнийзөрүү	1,767,741	1,767,741
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	401,310,784	382,567,696

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	238,119,852	245,725,622
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,596,352	5,000,000
120	Нийтлэг татварын бус орлого	8,596,352	5,000,000
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,596,352	5,000,000
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,596,352	5,000,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,523,500	240,725,622
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	216,289,000	218,120,500
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	216,289,000	218,120
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,862,722
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	223,802
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,638,920
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,234,500	13,742,400
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,234,500	13,742,400
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	249,205,169	264,468,709
21	УРСГАЛ ЗАРДАЛ	249,205,169	264,468,709
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	237,479,869	247,276,270
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,881,782	166,566,783
210101	Үндсэн цалин	162,885,689	94,862,356
210102	Нэмэгдэл	2,996,093	59,867,849
210104	Урамшуулал	-	11,836,578
2102	Ажил олгогчоос иийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,232,413	21,289,936
210201	Тэтгэврийн даатгал	14,217,253	14,953,001
210202	Тэтгэмжийн даатгал	1,675,313	1,664,266
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,340,250	1,331,412
210204	Ажилгүйдлийн даатгал	280,194	303,816
210205	Эрүүл мэндийн даатгал	2,719,400	3,037,439
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,160,700	12,101,400
210301	Гэрэл, цахилгаан	2,577,400	585,458
210302	Түлш, халаалт	13,183,300	11,515,942
210303	Цэвэр, бохир ус	400,000	-
2104	Хангамж, бараа материалын зардал	1,787,100	906,302
210401	Бичиг хэрэг	821,000	150,500
210402	Тээвэр, шатахуун	476,600	423,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	45,000	15,600
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	195,802

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,500	120,800
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	411,000	-
2105	Нормативт зардал	9,321,510	10,507,700
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	298,500	1,192,300
210502	Хоол, хүнс	8,944,010	8,462,450
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	79,000	852,950
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,664,000
210604	Урсгал засвар	-	1,664,000
2107	Томилолт, зочны зардал	-	71,900
210702	Дотоод албан томилолт	-	71,900
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,000	8,252,948
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	7,928,948
210802	Аудит, багалгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	324,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,896,364	25,915,301
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,600
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,923,600	2,650,350
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,972,764	23,261,351
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,725,300	17,192,439
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,530,920
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,530,920
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,725,300	8,661,519
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,725,300	8,661,519
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(11,085,317)</u>	<u>(18,743,087)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(11,085,317)</u>	<u>(18,743,087)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулан капитал	Дахинүнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувьоролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	792,728,729	1,767,741	(393,185,685)	401,310,784
C02	Нягтланбодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахинилэрхийлсэн үлдэгдэл	792,728,729	1,767,741	(393,185,685)	401,310,784
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	792,728,729	1,767,741	(393,185,685)	401,310,784
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	792,728,729	1,767,741	(393,185,685)	401,310,784
D03	Дахинилэрхийлсэн үлдэгдэл	792,728,729	1,767,741	(393,185,685)	401,310,784
D08	Тайлант үеийн нүрдүн			(18,743,087)	(18,743,087)

D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	792,728,729	1,767,741	(411,928,773)	382,567,696
-----	---------------------------------------	-------------	-----------	---------------	-------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>229,523,500</u>	<u>240,725,622</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,523,500	240,725,622
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	216,289,000	218,120,500
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	216,289,000	218,120,500
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,862,722
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	223,802
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,638,920
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,234,500	13,742,400
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,234,500	13,742,400
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>229,523,500</u>	<u>240,725,622</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	229,523,500	240,725,622
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	217,798,200	223,533,183
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,958,219	166,646,547
210101	Үндсэн цалин	97,977,134	94,862,356
210102	Нэмэгдэл	53,025,242	59,947,613
210104	Урамшуулал	14,955,843	11,836,578
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,155,737	21,289,936
210201	Тэтгэврийн даатгал	15,072,637	16,008,300
210202	Тэтгэмжийн даатгал	1,270,700	1,545,700
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,016,800	1,127,825
210204	Ажилгүйдлийн даатгал	254,000	234,500
210205	Эрүүл мэндийн даатгал	2,541,600	2,373,611
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,582,700	12,077,400
210301	Гэрэл, цахилгаан	2,577,400	585,458
210302	Түлш, халаалт	9,605,300	11,491,942
210303	Цэвэр, бохир ус	400,000	-
2104	Хангамж, бараа материалын зардал	805,700	1,048,002
210401	Бичиг хэрэг	78,100	150,500
210402	Тээвэр, шатахуун	476,600	423,600

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	64,200	15,600
210404	Ном, хэвлэл	44,500	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	331,802
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	142,300	126,500
2105	Нормативт зардал	15,519,705	10,028,350
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,630,900	41,900
210502	Хоол, хүнс	12,822,105	9,590,250
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,066,700	396,200
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,664,000
210604	Урсгал засвар	-	1,664,000
2107	Томилолт, зочны зардал	-	71,900
210702	Дотоод албан томилолт	-	71,900
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	216,500	8,243,848
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,500	7,919,848
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	324,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,559,639	2,463,200
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,559,639	2,463,200
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,725,300	17,192,439
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,530,920
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,530,920
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,725,300	8,661,519
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,725,300	8,661,519
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийнзаасгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	231,862,900	223,201,381
21	УРСГАЛ ЗАРДАЛ	231,862,900	223,201,381
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	231,862,900	223,201,381
2101	Цалинхөлс болон нэмэгдэл урамшил	168,509,200	166,646,547
210101	Үндсэн цалин	97,257,500	94,862,356
210102	Нэмэгдэл	60,641,800	59,947,613
210104	Урамшуулал	10,609,900	11,836,578

2102	Ажиллогччооснийгмийндаатгалдтөлөхшимтгэ л	22,748,700	21,289,936
210201	Тэтгэврийндаатгал	16,008,300	16,008,300
210202	Тэтгэмжийндаатгал	1,685,100	1,545,700
210203	ҮОМШӨ-нийдаатгал	1,348,100	1,127,825
210204	Ажилгүйдлийндаатгал	337,000	234,500
210205	Эрүүлдмэндийндаатгал	3,370,200	2,373,611
2103	Байрашиглалттайхолбоотойтогтмолзардал	12,077,400	12,077,400
210301	Гэрэл, цахилгаан	1,077,400	585,458
210302	Түлш, халаалт	10,600,000	11,491,942
210303	Цэвэр, бохирус	400,000	0
2104	Хангамж, барааматериалынзардал	716,200	716,200
210401	Бичигхэрэг	69,400	150,500
210402	Тээвэр, шатахуун	423,600	423,600
210403	Шуудан, холбоо, интернэтийнтөлбөр	57,100	15,600
210404	Ном, хэвлэл	39,600	-
210406	Багаүнэтэй, түргэнэлэгдэх, ахуйнэдзүйлс	126,500	126,500
2105	Нормативтзардал	12,143,700	10,028,350
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийнхэрэгсэл	41,900	41,900
210502	Хоол, хүнс	11,705,600	9,590,250
210503	Нормынхувцас, зөөлөнэдтэл	396,200	396,200
2106	Эдхогшил, урсгалзасварынзардал	1,665,000	1,664,000
210604	Урсгалзасвар	1,665,000	1,664,000
2107	Томиллолт, зочнызардал	71,900	71,900
210702	Дотоодалбантомиллолт	71,900	71,900
2108	Бусдааргүйцэтгүүлсэнажил, үйлчилгээнийтөлбөр, хураамж	11,467,600	8,243,848
210801	Бусдааргүйцэтгүүлсэнбусаднийтлэгажилүйлчилгэ энийтөлбөрхураамж	11,143,600	7,919,848
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэлтогтоох	324,000	324,000
2109	Барааүйлчилгээнийбусадзардал	2,463,200	2,463,200
210902	Хичээлүйлдвэрлэлийндадлагахийх	2,463,200	2,463,200
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	231,862,900	231,862,900
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	218,120,500	218,120,500
131007	Тусгайзориулалтыншилжүүлгээсанхүүжих	218,120,500	218,120,500
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,742,400	13,742,400
132001	Ороннутгийнтөсвөөс	13,742,400	13,742,400
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийнбайгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13	13
620001	Удирдахажилтан	1	1
620002	Гүйцэтгэажилтан	7	7
620003	Үйлчлэажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	13	13
650004	СЭБ болонбага, дундболовсролынлбанхаагч (ТҮБД)	8	8
650009	Терийнүйлчилгээнийбусадлбанхаагч (ТҮ)	5	5

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дуут сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалынталаар болонаудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуультай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыгаудитор А.Оюундэлгэр 2022 оны 01 дүгээр сарын 20-нээс 2021 оны 01 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1дүгээр сарын 20-ний өдрийн 02 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дуут сумын хүүхдийн цэцэрлэг нь сумын 2-5 насны бүх хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургах ажлыг үр дүнтэй зохион байгуулан, сургуулийн өмнөх боловсролд 5-н настай хүүхдийг бүрэн хамруулж, цэцэрлэгийн хамран сургалтыг 0,3 хувиар ахиулж, үндсэн болон хувилбарт, явуулын чиглэлээр үйлчилгээг хүргэж хамтарч ажиллах, Монгол улсын засгийн газраас баталж гаргасан тогтоол шийдвэр, аймаг, суманд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, үр дүнг нээлттэй болгон ажиллаж байгаа сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх байгууллага юм.

Тус байгууллага нь 2021 онд “Цэцэрлэгийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог өргөжүүлж, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг сайжруулах, хүүхэд хамгаалалын хөтөлбөрийг хэрэгжүүлж нийгмийн эргэх хариуцлагыг нэвтрүүлж сайжруулах” зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бөгөөд 2020 оноос шинэчлэгджээ.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Хяналт шинжилгээ үнэлгээ аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дуут сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөрсонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны нийт орлогын 324.5 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 4.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дуут сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18.7 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд 1.9 сая төгрөгийн авлагатай байсан ба 1.5 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажиллаа. Тайлант онд 1.5 сая төгрөгийн хувь хүмүүсээс авах авлага, мөн 79.7 мянган төгрөгийг үйлдвэрчний эвлэлд илүү төлсөөнөөс үүдэн үүссэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 24.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 25.4 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 476 сая төгрөг, оны эцэст 481 сая төгрөг болж 5 сая төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-гийн санхүүжилтаар сантехникийн холболтын засвар хийсэнтэй холбоотой байна.

Тайлант онд худалдаж авсан болон акталсан хөрөнгө байхгүй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 401.3 сая төгрөг байсан оны эцэст 382.5 сая төгрөг болж тайлант онд 18.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -18.7 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дуут сумын хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 249.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 249.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөсөн боловч нэг удаагийн тодотгол орж санхүүжилтын эх үүсвэр 231.8 сая төгрөг болж 17.6 сая төгрөгөөр буурсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээс 218.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 13.7 сая төгрөг нийт 231.8 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 231.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 223.2 сая төгрөгийг зарцуулж төсөвт 8.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 223.2 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 1.8 сая төгрөгөөр, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1.4 сая төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 2.1 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад төлбөр хураамж зардлыг 3.2 төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 8.8 сая төгрөгийн орлого, зардлын гүйлгээ дамжсан бөгөөд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмж 8.5 сая төгрөг, 0.3 сая төгрөг ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээллэж 11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаартөсвийг Бараа материалын зардал шилжүүлэхдээ е- баримтаар баталгаажуулан гүйлгээ хийж өглөг авлагыг тооцон ажиллах, Хүнсний бүтээгдэхүүн болон махны гарал үүслийн бичиггүй, хүүхдийн хоолны талон засварласан, хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, няравын тайлан эмх цэгцгүй гэсэн 3 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувь хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар И баримт аваагүй гүйлгээ халаалтын 1, бараа материалын 2 баримт 3.5 сая төгрөгний И баримт аваагүй гүйлгээ хийсэн. Шилэн дансны 11 мэдээг хугацаа хоцруулсныг зөрчлөөр бүртгэж зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 3.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 79.7 мянган төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3.4 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

ҮЭ татварт 14 гүйлгээгээр 934.0 төгрөг шилжүүлж, цалингаас суутгасан ҮЭ татвар 854.3 мянган төгрөг зөрүү 79.7 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй байна.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 И Баримттай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Аудитаар И баримт аваагүй гүйлгээ халаалтын 1, бараа материалын 2 баримт 3.5 сая төгрөгний И баримт аваагүй гүйлгээ хийсэн.

4.1 Өгсөн зөвлөмж: "Татварын ерөнхий хуулийн 28.5.Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" заалтыг мөрдөн И баримтаар гүйлгээ хийдэг байх

4.2 Илрүүлэлт 2021.01 сард шилэн дансны 11 мэдээ хугацаа хоцорсон. Материаллаг бус гэж үзээд шилэн дансны үр дүнг зөвлөмжөөр шийдвэрлэхээр болов.

4.2 Өгсөн зөвлөмж: “Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалтыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дуут сумын хүүхдийн цэцэрлэг	3	3.6	1	0.1	0	0.0	0	0	2	3.5

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЯДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:



А.ОЮУНДЭЛГЭР

